

**Арлингтон нийтийн сургуулиудын Гэр бүлийн амьдралд боловсрол олгохоос Эцэг  
эхийн татгалзах маягт - 10-р АНГИ**

СУРАГЧИЙН НЭР: \_\_\_\_\_ УТАСНЫ ДУГААР: \_\_\_\_\_

БАГШИЙН НЭР: \_\_\_\_\_ ОГНОО: \_\_\_\_\_

Миний бие үүгээр хүүхдээ дараахь зорилтуудаас татгалзах гэсэн сонголтыг хийж байна. Би хүүхдээ татгалзуулсан зорилгынхоо оронд манай хүүхдэд бие даан гүйцэтгүүлэх өөр даалгавар өгөх болно гэдгийг ойлгож байна. Хүүхэд өөр даалгавар дээр ажиллаж байхдаа сургуулийн дүрэм, журмыг дагаж мөрдөх ёстой бөгөөд энэ даалгаварт үнэлгээ өгнө гэдгийг бас ойлгож байна.

**ЗӨВЛӨГӨӨ:** Хүүхдээ татгалзуулахыг хүссэн зорилго тус бүрийн хажуу талд өөрийн нэрний эхний үсгийг тавиарай.

\_\_\_ **10.1 Нас биенд хүрэх нь өсвөр насныханд хэрхэн нөлөөлдгийг сурагч тодорхойлно.**

Тодорхойлох тайлбар: Өсвөр насны өсөлт хөгжлийн үйл явцыг өөрийгөө харах өнцөг, өөртөө итгэх итгэл, бие физиологийн өөрчлөлтүүд, хүний хэрэгцээний Тодорхойлох тайлбар, сэтгэл хөдлөлд эерэг хариу үзүүлэхүй, сэтгэцийн эрүүл мэндийн эерэг зуршлууд, шийдвэр гаргах үйл явц, үнэ цэнийн эх үүсвэр, өөрийгөө захирах зэрэгтэй холбон авч үзнэ.

\_\_\_ **10.2 Оюутан өөрийгөө болон хүн хоорондын харилцааны хүлээлттэй холбоотой өөрийн хандлагыг тодорхойлно.**

Тодорхойлох тайлбар: Зөв нөхөрлөл, болзоо болон найз нөхдөөрөө хийх зүйлс, харилцаа үүсгэх үе шатууд, идэвх чармайлт, хайрын төрөл, харилцаа холбоо, хувь хүн, гэр бүлийн үүргүүдийг авч үзнэ. Мөн виртуал харилцааны төсөөллийн талаар хэлэлцэнэ.

\_\_\_ **10.3 Хүмүүс хоорондын эерэг харилцааг бүрдүүлж хадгалахад зайлшгүй шаардлагатай үнэ цэнэ, ёс суртахуун, ёс зүйн талаар тунгааж үзнэ.**

Тодорхойлох тайлбар: Шударга байх, итгэл даах чадвар, өөрийгөө хянах, өөрийн болон бусдын өмнө хариуцлага хүлээх, нийгмийн шударга ёс болон ёс суртахуун, ёс зүйн тогтолцооны хөгжлийн талаар хэлэлцэнэ. Бэлгийн харилцаанд орохын өмнө зөвшөөрөл шаардлагатай байдаг талаарх ойлголтыг дэлгэрүүлэхийн тулд бэлгийн харилцааны утга учир, хууль дүрмийн талаар ярилцахаас гадна бэлгийн чиг хандлагыг тойрсон нийгэм, сэтгэл хөдлөл, харилцааны нөлөөллүүд, бусдын татгалзах эрхийг хүндэтгэх талаар ярилцана. Цахим хэлбэрээр бэлгийн дарамт үзүүлэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн контент орно. Хүмүүсийн хоорондох эерэг харилцааны үндэс болон хүчлэх, залилах, дарамт шахалт үзүүлэх үед хүний наймаа зэрэг хүчирхийлэл гарч болох талаар сурагчид ойлгож авна.

\_\_\_ **10.4 Сурагч шийдвэр гаргах үйл явц дахь алхамуудыг ашиглан тодорхой асуудлуудыг шийднэ.**

Тодорхойлох тайлбар: Энэхүү зааврын хүрээнд хувь хүн, нийгэм, нөхдийн зүгээс үзүүлэх дарамт шахалт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн зүгээс өгч буй мессежтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцын зургаан алхамыг заана. Алхамуудад дараах багтана: асуудлыг тодорхойлох; байж болох бүх сонголтуудыг жагсаан бичих; сонголтууд болон тэдний үр дагавруудад хувийн болон гэр бүл, нийгмийн итгэл үнэмшилд суурилан үнэлгээ хийх;

өөрийн, бусдын, нийгмийн сайныг гаргаж ирэх сонголтыг сонгох; шийдвэрээ хэрэгжүүлэх; үр дүнг үнэлэх. Нийгмийн зүгээс сонголтуудад үнэлгээ хийхэд тус болох материал баазуудыг тодорхойлно.

\_\_\_ **10.5 Сурагч гэрлэхийн өмнөх бэлгийн харилцаанаас татгалзахын ашиг тусыг тодорхойлно.**

Тодорхойлох тайлбар: Амьдралын зорилгуудыг бэлгийн харилцаанд дуудсан одоогийн шахалтуудтай уялдуулан авч үзэх хэрэгцээ шаардлагад контент чиглэнэ. Эцэг эх болоход бэлэн байгаа эсэх, төлөвлөөгүй жирэмслэлтийн үр дагаврууд, бэлгийн замын халдварт өвчний үр нөлөө, нэр хүнд, сэтгэцийн эрүүл мэнд болон одоо, ирээдүйн зорилгод үзүүлэх нөлөөллүүд, гэр бүлийн үнэт зүйлсийг дагаж мөрдөхийн ашиг тус, боловсролын төлөвлөгөөгөө дуусгах шаардлага, санхүүгийн үүрэг хариуцлагад үзүүлэх ачаалал, ирээдүйн зорилго, ажлын боломжид учруулах саад зэрэг сэдвийг авч үзнэ. Гэрлэх хүртлээ бэлгийн харилцааг хойшлуулахын эерэг давуу талуудыг онцолно. Сурагчид хувийн, боловсрол, ажил мэргэжлийн зорилгоо тодорхойлж, төлөвлөөгүй жирэмслэлт эсвэл бэлгийн замаар дамжих халдвар нь эдгээр зорилгод нөлөөлөхийг онцолно. Үүнээс гадна жирэмслэлтээс сэргийлэхэд 100 хувь үр дүнтэй цорын ганц арга нь бэлгийн харилцаанд орохгүй байх болохыг онцолно.

\_\_\_ **10.6 Сурагч гэрлэхийн өмнөх бэлгийн харилцаанаас өөр сэтгэл, мэдрэмжээ илэрхийлэх зүйлсийг тодорхойлно.**

Тодорхойлох тайлбар: Сурагчдыг бэлгийн харилцаанд орох бус ярилцах; санаа бодол, үнэт зүйлс, зорилго илэрхийлэх; нийгмийн харилцаанд орох, нийгмийн үйлчилгээнд оролцох; биеийн эерэг хэл, эерэг үйл хөдлөл, сэтгэцийн эрүүл мэндийн бусад эерэг зуршлуудаар дамжуулан сэтгэл мэдрэмжээ илэрхийлэхийг уриална.

\_\_\_ **10.7 Сурагч болзоо, гэрлэлтэнд бэлдэхэд бодолцож үзэх шаардлагатай хүчин зүйлсийг тайлбарлана.**

Тодорхойлох тайлбар: Нөхөрлөл, болзоо (энгийн, бүлгийн, ганцаарчилсан, харанхуй, байнгын, виртуал, гэрлэлтэнд хүргэх), үерхэх хүнээ сонгох зэрэг харилцаатай холбоотой алхамуудыг тодорхойлно. Эерэг, эрүүл харилцааг бий болгох алхамуудыг мөн ярилцана. Бэлгийн харилцааны зөвшөөрлийн утга учир, бусдын татгалзах эрхийг хүндэтгэх, бэлгийн харилцааны нийгэм, сэтгэл зүйн нөлөөлөл, болзооны хүчирхийлэл, хүчирхийлэл бүхий харилцааны шинж тэмдгийг тодорхойлох заавруудыг орно. Тухайн сурагчийг хувийн нууц болон бусдын хил заагийг хүндэтгэдэг болгохын тулд өөрийн болон бусдын хувийн нууц, хил заагийг хүндэтгэхийн ач холбогдлыг судлан үүнтэй холбоотой хэрэгслүүдийг олгоно.

\_\_\_ **10.8 Сурагч амьдрал төлөвлөлтөд бодолцож үзэх шаардлагатай хүчин зүйлсийг тунгааж үзнэ.**

Тодорхойлох тайлбар: Эдийн засаг, мэргэжил дээшлүүлэх боловсролтой холбоотой насан туршийн ажил мэргэжлийн зорилгууд, үнэнч харилцаа, гэрлэлтийн боломж бололцоо, гэр бүлийн бэлтгэл, ажил мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө зэргийг ярилцана. Жирэмснээс хамгаалах аргууд зэрэг гэр бүл төлөвлөлтийн талаар судлана.

\_\_\_ **10.9 Сурагч жирэмсэний шинж тэмдгийг тайлбарлана.**

Тодорхойлох тайлбар: Зааварчилгаа нь бие махбодийн болон сэтгэлзүйн өөрчлөлт, эрүүл, амжилттай жирэмслэлтийг хангах эмнэлгийн үзлэгээр жирэмслэлтийг эрт илрүүлэх хэрэгцээ зэргийг хамааруулна. Үзлэг шинжилгээ болон нэмэлт мэдээллийг авах нийтийн нөөцийг тодорхойлно.

\_\_\_ **10.10 Сурагч эрүүл жирэмслэлттэй холбоотой хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийнэ.**

Тодорхойлох тайлбар: Хүүхэд бага жинтэй төрөхийн шалтгаанууд болох тамхи татах, тэжээлийн дутагдал, архи, мансууруулах бодисын хэрэглээ, зохисгүй хэрэглээ болон Хүний дархлал хомсдолын вирус зэрэг бэлгийн замын халдварын үр нөлөөнд чиглэсэн контент орно. Төрөхийн өмнөх үеийн асаргааны ач холбогдол зэрэг эрүүл мэндийн сайн, муу зуршлуудын бусад үр дагавруудыг онцолж үзнэ.

\_\_\_ **10.11 Сурагч жирэмслэлт, төрөхийн үед үзүүлэх эцэг эхийн тусламж дэмжлэгийн ач холбогдлыг тайлбарлана.**

Тодорхойлох тайлбар: Төрөхийн өмнөх зохистой асаргаатай холбоотой эцэг эхийн үүрэг хариуцлага, удамшлын нөлөө, зулбалт, төрөлхийн гажиг, амьгүй төрөлт, дутуу төрөлт зэрэг хэвийн бус төрөлт, төрөхийн өмнөх ургийн хөгжлийн үе шатууд зэрэг сэдвийн талаар ярилцана.

\_\_\_ **10.12 Сурагч хүүхэд төрүүлэх арга сонголтуудыг тайлбарлана.**

Тодорхойлох тайлбар: Хүүхэд төрөлтийн боловсролд зориулж бэлтгэсэн материалууд нь анхдагч материал байна. Хүүхэд төрүүлэх аргуудыг судлана.

\_\_\_ **10.13 Сурагч төрөх үйл явцын үе шатуудыг тодорхойлно.**

Тодорхойлох тайлбар: Төрөх үйл явцын үе шатуудад үйл явцын гараа болон базлалт, хүүхэд гарах, ихэс гарах гэсэн төрөлтийн гурван үе шат багтана.

\_\_\_ **10.14 Сурагч чадвартай эцэг эх болоход шаардлагатай ур чадвар, хандлагуудад дүн шинжилгээ хийнэ.**

Тодорхойлох тайлбар: Хүүхэд өсгөх аргуудад хандах хандлагуудыг судлана. Мөн мэргэжилтнүүдийн тодорхойлсон хүүхэд өсгөх янз бүрийн стратегиудыг заана. Сурагчдад өөрсдийн хөгжүүлэхийг хүсч буй хүүхэд өсгөх ур чадваруудыг тодорхойлох боломжийг олгоно. Сурагчид хүүхэд өсгөх үүрэг хариуцлагын ач холбогдлыг ойлгож авна. Мөн хүүхэд өсгөхөд харилцаа/гэрлэлтдээ үнэнч байхын ашиг тус, бэрхшээл сорилт, хариуцлага, үнэ цэнийг ойлгож авахаас гадна эцэг эхчүүдэд нээлттэй нийгэм, гэр бүлийн дэмжлэгийн тогтолцоонуудыг тодорхойлж чаддаг болно. Сурагчид мөн эцэг эх байхын сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөнүүдийг ойлгож авна.

\_\_\_ **10.15 Сурагч хүүхэд төрсөний дараах хийх шаардлагатай зохицуулалтуудыг тайлбарлана.**

Тодорхойлох тайлбар: Нярай хүүхэд баяр хөөр, хайрын эх үүсвэр болдгийг онцлох боловч орлого, боловсролын төлөвлөгөө, чөлөөт цаг, унтах цаг, хувийн харилцаанд үзүүлэх нөлөө зэрэг шинэ мэндэлсэн нярай хүүхдийг асрахын гэр бүлд үзүүлэх нөлөөг судлана.

\_\_\_ **10.16 Сурагч хувь хүн, гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлэх нийгмийн агентлаг, материал сурвалжуудын жагсаалтыг гаргана.**

Тодорхойлох тайлбар: Жагсаалтанд оруулах нийгмийн дэмжлэгүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн үйлчилгээ, шашны байгууллагууд, хувийн агентлагууд, өдөр өнжүүлэх төвүүд, өндөр настнуудыг асрах төв, эрүүл мэндийн хэлтэс зэрэг орно. Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хүчирхийлэл, хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн хулгай, хүний наймаа, амиа хорлолтын утаснуудыг бичнэ.

\_\_\_ **10.17 Сурагч гэр бүлийн амьдралын эерэг талыг нийгмийн үндсэн нэгж болон хувь хүнийг хөгжүүлэх арга замын үүднээс бодолцож үзнэ.**

Тодорхойлох тайлбар: Гэр бүлийн үүрэг, хэлбэрүүд, ялангуяа гэр бүлийн харилцаа, гэр бүлийн харилцааны үнэ цэнийн талаар заана. Гэр бүлийн нэгжийг гэрлэсэн эсвэл ганц бие хүний хувьд зан чанарыг нь бүрэлдэн бий болгодог, нас биенд хүрэхэд бэлтгэдэг үндсэн хүчин зүйл гэж тайлбарлана. Гэр бүлийн нэгжийн нийгэм, цаашлаад хорвоо дэлхийтэй харилцах харилцааг онцолж авч үзнэ.

**ЭНЭХҮҮ МАЯГТЫГ СУРГУУЛИАС ТОГТООСОН ХУГАЦААНД БӨГЛӨЖ ЗАХИРАЛ  
РУУ БУЦАНА УУ.**

ЭЦЭГ ЭХ/АСРАН ХАМГААЛАГЧИЙН ГАРЫН ҮСЭГ:

\_\_\_\_\_ ОГНОО: \_\_\_\_\_